

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЪЯАТЫН ГАЗАР
АГААРЫН ЗАМЫН БООМТ ХАРИУЦСАН ГАЗАР

БАТЛАВ.

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЪЯАТЫН ГАЗАР
АГААРЫН ЗАМЫН БООМТ ХАРИУЦСАН
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



/З.ДАВААСҮРЭН/

[ГАДААДЫН ИРГЭН, ХАРЪЯАТЫН ГАЗАР АГААРЫН ЗАМЫН БООМТ
ХАРИУЦСАН ГАЗАРТ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ЭД ХОГШИЛ]
НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ШАЛГАРУУЛАХ

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР: ТӨАОНӨГ/202012068

ТӨВ, ЗУУНМОД ХОТ
2020 ОН

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЪЯАТЫН ГАЗАР
АГААРЫН ЗАМЫН БООМТ ХАРИУЦСАН ГАЗАР

БАТЛАВ.

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЪЯАТЫН ГАЗАР
АГААРЫН ЗАМЫН БООМТ ХАРИУЦСАН
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

/З.ДАВААСҮРЭН/

**[ГАДААДЫН ИРГЭН, ХАРЪЯАТЫН ГАЗАР АГААРЫН ЗАМЫН БООМТ
ХАРИУЦСАН ГАЗАРТ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ЭД ХОГШИЛ]
НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ШАЛГАРУУЛАХ**

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР: ТӨАОНӨГ/202012068

**ТӨВ, ЗУУНМОД ХОТ
2020 ОН**

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

[Гадаадын иргэн, харъяатын газар Агаарын замын боомтын хариуцсан газар] нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **[Гадаадын иргэн, харъяатын газар Агаарын замын боомт хариуцсан газарт тоног төхөөрөмж, эд хогшил ТӨАОНӨГ/202012068]** нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр Тендерийн материалыг Цахим худалдан авах ажиллагааны систем (**www.tender.gov.mn**) хаягаар өөрийн ААНэгжийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (**PDF**) файлаар илгээнэ.

Цахим систем ашиглан илгээх нийт файлын хэмжээ **100 mb**, нэг файлын хэмжээ **15 mb**, байна.

Цахим тендер зохион байгуулалт, журмын дагуу тендерт оролцох хураамж **20,000 /хорин мянган/** төгрөгийг (**www.tender.gov.mn**)-ээр банкны **Е-Меркантийн системийг** ашиглан төлнө. Үнийн санал ирүүлэх материалын техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **[2020 оны 4 дүгээр сар 21-ний өдрийн 11:20 минут]-аас** өмнө **[төрийн худалдан авах ажиллагааны нэгдсэн систем болох www.tender.gov.mn]** хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **[2020 оны 4 дүгээр сар 21]-ний өдрийн [11:30 минут]¹**-д нээнэ.

Дотоодны давуу эрх тооцох эсэх. тооцохгүй

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

[Төв аймаг Зуунмод сум 6-р баг Төр захиргааны 2-р байрны 2 давхарын 201 тоот утас 70273579]

¹ Тендерийг хүлээж авах эцсийн хугацааг дууссанаас хойш 1 цагийндотор байна.

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- | | |
|---|--|
| 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна. |
| 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ. |
| 3. Тендерийн иж бүрдэл | 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
(а) Үнийн санал;
(б) Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь;
(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.] |
| 4. Тогтмол үнэ | 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана. |
| 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд | 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ. |
| 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа | 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30хоногийн хугацаанд хүчинтэй байна. |

7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>1. Сүүлийн [2] жилийн 2018, 2019 санхүүгийн тайланг аудитын дүгнэлтийн хамт хуулбарлан ирүүлэх/</p> <p>2. Сүүлийн [2 жил] 2018, 2019 онуудын туршлагын мэдээлэл, бараа нийлүүлсэн гэрээ, хүлээлгэн өгсөн актын хуулбар, фото зургийн хамт ирүүлэх/;</p> <p>3. Сүүлийн [2 жил] 2018, 2019 онуудад хийж гүйцэтгэсэн ижил төстэй ажлуудын дундаж өртөг нь 35,000,000 төгрөгөөс багаүй байх</p> <p>Тендерт оролцогч гэрээг хэрэгжүүлэх чадвартайг нотлохын тулд захиалагч дараах нэмэлт нотлох баримтыг тендерийн хамт ирүүлэх:</p> <p>4. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар</p> <p>5. Компани нь хугацаа хэтэрсэн зээлийн батлан даалтын гэрээгээр хүлээсэн өр төлбөргүй тухай тодорхойлолт. Тендер нээсэн өдрийн байдлаар хүчинтэй байна.</p> <p>6. Харъяа Нийгмийн даатгалын санд өр төлбөргүй тодорхойлолт ирүүлнэ. Тендер нээсэн өдрийн байдлаар хүчинтэй байна.</p> <p>7. Шүүхийн ерөнхий зөвлөлийн төрөлжсөн архив, ШШГГ-ын тодорхойлолт ирүүлэх, мөн тус газруудаас тодруулга авахад татгалзах зүйлгүй гэсэн албан бичиг ирүүлэх</p> <p>8. Монгол улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байх бөгөөд зөвхөн Татварын ерөнхий газрын www.e-tax.mta.mn сайтыг ашиглан цахим тодорхойлолт авч ирүүлэх ба энэхүү тодорхойлолт нь тендер нээсэн өдрийн байдлаар хүчинтэй байна.</p> <p>9. Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл, баримт бичгийг бэлтгэн цахим хэлбэрт оруулж ирүүлэх ба ирүүлсэн бүх материал тод, уншигдахуйц, бичиг хэргийн стандарт шаардлага хангасан байх шаардлагатай. Хэрэв тод биш, уншигдахааргүй тендерийн материал ирүүлсэн бол иж бүрдэл дутуу гэж үзэн тухайн тендерээс татгалзах үндэслэл болно.</p> <p>10. Тендерт оролцогч нь санал үнийн дүнд багтаан тухайн ажлыг чанартай дуусгаж хүлээлгэн өгөх баталгааг бичгээр гаргаж ирүүлнэ.</p> <p>11. Тендерт оролцогчийн үнийн саналыг олон нийтэд мэдээллэхэд</p>

	<p>татгалзах зүйлгүй тухай мэдэгдлийг ирүүлнэ.</p> <p>12. Техникийн тодорхойлолтод заагдсан стандартын шаардлагыг хангасан талаарх албан мэдэгдэлийг тодорхойлж ирүүлнэ. /захиалагч шаардлага хангаагүй стандарт бус төхөөрөмж хүлээн авахгүй болно./</p> <p>13. Тендерт оролцогч төхөөрөмжийн фото зургыг гаргаж үндсэн үзүүлэлт, хүчин чадал, зориулалт зэргийг тодорхойлсон баримт, материалыг гаргаж ирүүлнэ.</p> <p>14. Тендерт оролцогч чанарын баталгаа буюу баталгаат хугацааг тодорхойлсон албан мэдэгдэл ирүүлнэ.</p> <p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай байх. Шаардлагагүй</p> <p>Дараах үндсэн тоног төхөөрөмжийг ажлыг гүйцэтгэх хугацаанд (өөрийн) бэлэн байлгах шаардлагатай. Техник, тоног төхөөрөмжийн жагсаалт, зураг, гэрчилгээ зэргийг тендерийн баримт бичигт бүрдэл болгож ирүүлнэ.Үүнд:</p> <p>15. Ачааны авто машины гэрчилгээний хуулбар ТШӨХ-н ТӨӨЗ 1.1-д заасан өгөгдөл, шаардлагын аль нэгийг хангаагүй бол тухайн тендерээс татгалзана.</p>
<p>ТӨӨЗ 2.1</p>	<p>Тендер хүлээн авах захиалагчийн хаяг: Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn)–д өөрийн аж ахуйн нэгжийн хувийн нууцлалын кодоор нэвтрэн орж тендерийн материалаа цахим хэлбэрээр ирүүлнэ.</p> <p>Огноо: 2020 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр</p> <p>Цаг: 11 цаг 20 минут</p>
<p>ТӨӨЗ 2.1</p>	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Төв аймаг, Зуунмод сум, 6-р баг, “Төр захиргааны 2 дугаар байр”, ОНӨГХАААлба.</p> <p>Давхар болон өрөөний дугаар: Төв аймгийн Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны алба, өрөөний дугаар 201 тоот.</p> <p>Аймаг, хот: Төв аймаг Зуунмод хот</p> <p>Улс: “Монгол Улс”</p> <p>Огноо: 2020 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр</p> <p>Цаг: 11 цаг 30 минут</p>
<p>ТӨӨЗ 2.3</p>	<p>Дөрөвдүгээр бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Сүүлийн [2] жилийн 2018, 2019 санхүүгийн тайланг аудитын дүгнэлтийн хамт хуулбарлан ирүүлэх/ 2. Сүүлийн [2 жил] 2018, 2019 онуудын туршлагын мэдээлэл, бараа нийлүүлсэн гэрээ, хүлээлгэн өгсөн актын хуулбар, фото зургийн хамт ирүүлэх/; 3. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар 4. Компани нь хугацаа хэтэрсэн зээлийн батлан даалтын гэрээгээр хүлээсэн өр төлбөргүй тухай тодорхойлолт. Тендер нээсэн өдрийн байдлаар хүчинтэй байна. 5. Харьяа Нийгмийн даатгалын санд өр төлбөргүй тодорхойлолт ирүүлнэ. Тендер нээсэн өдрийн байдлаар хүчинтэй байна. 6. Шүүхийн ерөнхий зөвлөлийн төрөлжсөн архив, ШШГГ-ын тодорхойлолт ирүүлэх, мөн тус газруудаас тодруулга авахад татгалзах зүйлгүй гэсэн албан

	<p>бичиг ирүүлэх</p> <p>7. Монгол улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байх бөгөөд зөвхөн Татварын ерөнхий газрын www.e-tax.mta.mn сайтыг ашиглан цахим тодорхойлолт авч ирүүлэх ба энэхүү тодорхойлолт нь тендер нээсэн өдрийн байдлаар хүчинтэй байна.</p> <p>8. Тендерт оролцогч нь санал үнийн дүнд багтаан тухайн ажлыг чанартай дуусгаж хүлээлгэн өгөх баталгааг бичгээр гаргаж ирүүлнэ.</p> <p>9. Тендерт оролцогчийн үнийн саналыг олон нийтэд мэдээллэхэд татгалзах зүйлгүй тухай мэдэгдлийг ирүүлнэ.</p> <p>10. Техникийн тодорхойлолтод заагдсан стандартын шаардлагыг хангасан талаарх албан мэдэгдэлийг тодорхойлж ирүүлнэ. /захиалагч шаардлага хангаагүй стандарт бус төхөөрөмж хүлээн авахгүй болно./</p> <p>11. Тендерт оролцогч төхөөрөмжийн фото зургыг гаргаж үндсэн үзүүлэлт, хүчин чадал, зориулалт зэргийг тодорхойлсон баримт, материалыг гаргаж ирүүлнэ.</p> <p>12. Тендерт оролцогч чанарын баталгаа буюу баталгаат хугацааг тодорхойлсон албан мэдэгдэл ирүүлнэ.</p> <p>Дараах үндсэн тоног төхөөрөмжийг ажлыг гүйцэтгэх хугацаанд (өөрийн) бэлэн байлгах шаардлагатай. Техник, тоног төхөөрөмжийн жагсаалт, зураг, гэрчилгээ зэргийг тендерийн баримт бичигт бүрдэл болгож ирүүлнэ. Үүнд:</p> <p>13. Ачааны авто машины гэрчилгээний хуулбар</p>
ТӨЭЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: [Багцгүй]</p>

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

- 1. Барааны тодорхойлолт:** [Барааны тодорхойлолт, техникийн үзүүлэлтийг энд бичнэ.]
- 2. Стандарт:** Захиалагч холбогдох стандартыг заана. Эсхүл [Тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно.] гэж бичнэ
- 3. Баглаа, боодол:** [Барааг тээвэрлэх, хадгалах үеийн баглаа боодолд тавих нөхцөлийг тодорхой заана. Баглаа боодлын нөхцөлийг цаг уур, давс, барааны жин, ачих буулгах хэрэгсэл, далайгаар тээвэрлэх тохиолдолд хөлөг онгоцны тавцан дээр, эсхүл доор тээвэрлэх зэргийг харгалзаж тодорхойлно. Ачааг хэрхэн тэмдэглэх болон хаяглах, ямар баримт бичиг дагалдахыг энд тодорхойлно.]
- 4. Бараа хүргэх газар:** [Барааг хүлээж авах хаягийг бичнэ]
- 5. Бараа нийлүүлэлтийн хуваарь:**

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмындагуу бусад тендер торолцогч додил болгохыг үүгээр зөвшөөрч байна.
Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | | |
|--|-------|--|
| 1. Шалгах болон турших | 1.1. | Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. | Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [моо] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. | Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан моо] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. | Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|--|
| 1. Шалгах болон турших (ГЕН – 1) | 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.] |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) | <p>2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:</p> <ol style="list-style-type: none">1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;5) барааны гарал үүслийн гэрчилгээ. <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p> |
| 3. Баталгаат засвар (ГЕН-5) | <p>5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.</p> <p>[Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]</p> |
| 4. Төлбөр (ГЕН – 7) | <p>7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:</p> <p>Гэрээний үнийн дүнгийн [100]² хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.</p> |
| 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)³ | <p>9.1. Алданги оногдуулах хувь: [0.5%]</p> <p>Алдангийн нийт дүн: [10%]</p> |

²Ихэнх тохиолдолд 100 хувь байна. Шаардлагатай бол төлбөрийн хуваарийг өөрчилнө.

³ Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

ЗАХИАЛАГЧ	НИЙЛҮҮЛЭГЧ
_____	_____
(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
_____	_____
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
_____	_____
(Албан тушаал)	(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____ -наас _____ оны __ дугаар сарын ____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг⁵;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

⁴ Гэрээбайгуулахүедүүнийгхасна.

⁵ Хоёрталхарилцантохиролцожгэрээнийнөхцөлдоруулсанзайлшгүйшаардлагатайнэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]